

Хархорин ХК

2019 ОНЫ ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Хархорин ХК

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ, ХАРХОРИН СУМ, ЭРДЭНЭ-ТОЛГОЙ БАГ, УСЖУУЛАХ 00 |
УТАС: 99993800

Агуулга

1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН НЭР, ОРШИН БАЙГАА ХАЯГ:	2
2. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ:	2
3. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ	2
4. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТҮҮХ, ТУХАЙН ЗАХ ЗЭЭЛД ЭЗЭЛЖ БУЙ БАЙР СУУРЬ, СУДАЛГАА	2
5. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БАРАА БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАХ ЗЭЭЛД ГАРСАН ТОМООХОН ӨӨРЧЛӨЛТ, ҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ ҮҮСЧ БОЛОХ ЭРСДЛИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ.....	3
6. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН УДИРДЛАГА, ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДЫН ТАНИЛЦУУЛГА:	3
7. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН НИЙТ ГАРГАСАН ХУВЬЦААНЫ 5 БОЛОН ТҮҮНЭЭС ДЭЭШ ХУВИЙГ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:.....	4
8. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ (2019 ОНЫ 4-Р УЛИРЛЫН БАЙДЛААР).....	5
8.1. САНХҮҮГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	5
8.2. “ХАРХОРИН” ХК-ийн жилийн эцсийн САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ДҮГНЭЛТИЙН ТУХАЙ.....	6
8.3. ТАТВАРЫН ТАЙЛАНГИЙН ТУХАЙ (2019 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР):.....	11
9. КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ИХ ХЭМЖЭЭНИЙ БОЛОН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ	11
10. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН 2019 ОНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ	11
11. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ, ТҮҮНИЙ ШИЙДВЭР	30
12. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУЗ-ИЙН ШИЙДВЭРҮҮД.....	31
13. НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ	32

1. Үнэт цаас гаргагчийн нэр, оршин байгаа хаяг:

Хархорин ХК

Хаяг: Өвөрхангай аймаг, Хархорин сум, Эрдэнэ-толгой баг, Усжуулахын контор

Утас: 99993800

Факс: 70151955

Электрон хаяг: ganbat.battogtokh@gmail.com

2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэл:

1.	Оноосон нэр	Хархорин
2.	Хариуцлагын хэлбэр	Нээлттэй Хувьцаат Компани
3.	Регистрийн дугаар	2015471
4.	Улсын бүртгэлийн дугаар	1010001006
5.	Үүсгэн байгуулагдсан огноо	1996.04.29
6.	Үндсэн эрхлэх үйл ажиллагаа	Чацаргана тариалах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх

3. Үнэт цаас гаргагчийн зорилго, үйл ажиллагааны стратеги, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл

Үнэт цаас гаргагчийн зорилго: Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарт тэргүүлэгч, чацаргана тариалагч, чацарганы бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуйн нэгж болох.

Үйл ажиллагааны стратеги: “Хархорин” ХК нь Монгол Улсад төдийгүй дэлхийд томоохонд орох нийт 3,000 гаруй га талбай бүхий чацарганы “Үндэсний цэцэрлэгт хүрээлэн” байгуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Үүнээс 2007 – 2019 онд нийт 600 гаруй га талбайд чацаргана тариалаад байгаа бөгөөд чацарганы ургацын хэмжээ жил тутам нэмэгдэж байна.

4. Үнэт цаас гаргагчийн түүх, тухайн зах зээлд эзэлж буй байр суурь, судалгаа

“Хархорин” ХК нь Монгол Улсын эртний нийслэл Хархорин хот, одоогийн Өвөрхангай аймгийн Хархорин сумын Эрдэнэтолгой багийн нутаг дэвсгэрт байрлаж байна. Хархорин сум нь Улаанбаатар хотоос баруун тийш 360 км, Өвөрхангай аймгийн төвөөс зүүн хойш 130 км зайд оршдог.

“Хархорин” ХК нь анх 1956 онд БНМАУ-ын Засгийн газрын 100% хөрөнгө оруулалтаар Хархорин сум САА нэртэйгээр газар тариалан, мал аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулж ирсэн түүхтэй Монголын томоохон САА нэг юм. 1990 онд Монгол оронд Ардчилсан хувьсгал гарч ирсэнээр 1992 онд тус САА нь Хархорин ХК нэртэйгээр төрийн өмч хувийн өмчид шилжин 70% төр, 30% тухайн нутгийн ард иргэдэд өмчлөн холимог системээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн. 1992 оноос тус компанийн хэвийн ажиллагаа доголдож 2007 онд өмч хувьчлал буюу нээлттэй тендэр зарлан 100%, хувийн өмчид шилжсэн. Шилжсэн цагаас хойш тус компани нь өөрийн үндсэн үйл ажиллагааны чиглэлээ өөрчлөн Монгол Улсын засгийн газраас баталсан “Чацаргана”, “Ногоон хэрэм” хөтөлбөрийн хүрээнд, чацаргана үржүүлэх, тариалах чиглэлээр нийт 50 гаруй байнгын, ургац хураалтын үед түр зуурын 200-300 ажилтан ажиллагсадтай үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус компани нь Ерөнхий агрономич Л.Бямбасүрэнгээр ахлуулсан 6 бригад, бригадыг ахалсан мэргэжлийн 6 агрономичтойгоор агро үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг. Компанийн эзэмшлийн газар нутгийн хувьд 4000 гаруй га талбай, Орхон голоос эх авсан усалтын 19 км сувагтай, 2007 оноос эдүүгээ нийт 600 гаруй га талбайд чацарганы жимст цэцэрлэг байгуулах ажлыг амжилттай байгуулан ажиллаж байна. Мөн 2014 он ОХУ-аас гүзээлзгэнэ, бөөрөлзгөнө, алим гэх мэт төрлийн жимслэг ургамлыг нутагшуулах ажлыг зохион байгуулж байна.

“Хархорин” ХК нь Монгол Улсад хамгийн томд орох таримал чацарганы талбайтай бөгөөд бүрэн хүчин чадлаараа ажилласан тохиолдолд жилд нийт 2,000 гаруй тонн чацарганы жимс хураан авч дотоодын чацаргана боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлэх хүчин чадалтай.

Монголын Чацарганы холбооноос авсан мэдээллээр одоогийн байдлаар Монгол Улсын хэмжээнд нийт 40 гаруй том жижиг чацаргана боловсруулах үйлдвэр үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээрийн нийт хүчин чадлын хэмжээ нь жилд 5,000 орчин тонн түүхий чацаргана боловсруулах боломжтой. Үүнээс үзвэл “Хархорин” ХК нь дангаараа Монгол Улсын чацаргана боловсруулах үйлдвэрүүдийн нэг жилийн түүхий эдийн хэрэгцээний 25%-ийг хангах бололцоотой.

5. Үнэт цаас гаргагчийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд гарсан томоохон өөрчлөлт, үүнтэй холбоотой үүсч болох эрсдлийн тухай мэдээлэл:

Тайлант хугацаанд “Хархорин” ХК-ийн бараа бүтээгдэхүүний гол зах зээл болох жимс, жимсгэнэ, тэр дундаа чацарганы дотоод болон гадаад зах зээлд томоохон өөрчлөлт гараагүй болно.

Харин 2019 оны 12-р сараас өдийг хүртэл үргэлжилж байга Covid 19 коронавируст халдварын тархалттай холбоотойгоор үүсээд байгаа нөхцөл байдалтай холбоотойгоор цаашид компани нь өөрийн үйл ажиллагаагаа хэвийн явуулахад хүн хүчний нөөц бололцоо хомс болох, чацаргана жимс нь хүний дархлаа дэмждэг ач тустай хэдий ч улс орны төдийгүй дэлхий дахин үүсээд байгаа эдийн засгийн хямралаас үүдэн борлуулалт эрс багасах, компанийн санхүүгийн нөхцөл доройтох, төлбөрийн чадвар муудах зэрэг эрсдэл үүсэхээр байна.

6. Үнэт цаас гаргагчийн удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудын танилцуулга:

П.Бишрэл	ТУЗ-ийн Дарга
Л.Хосбаяр	ТУЗ-ийн ердийн гишүүн
О.Төмөрбаатар	ТУЗ-ийн ердийн гишүүн, Цалин, урамшууллын хорооны дарга
Ц.Энх-Амгалан	ТУЗ-ийн ердийн гишүүн, Аудитын хорооны гишүүн
Ж.Энхтөр	ТУЗ-ийн ердийн гишүүн, Нэр дэвшүүлэх хорооны дарга
П.Учрал	ТУЗ-ийн ердийн гишүүн

Б.Амарсанаа	ТУЗ-ийн хараат бус гишүүн, Аудитын болон Цалин, урамшуулалын хороодын гишүүн
С.Амгалан	ТУЗ-ийн хараат бус гишүүн, Аудитын хорооны дарга, Нэр дэвшүүлэх хорооны гишүүн
Б.Бүрэн	ТУЗ-ийн хараат бус гишүүн, Нэр дэвшүүлэх болон Цалин, урамшууллын хороодын гишүүн
Р.Саранцэцэг	Гүйцэтгэх захирал
Б.Ганбат	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
Д.Дашмаа	Ерөнхий нягтлан бодогч

7. Үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшигчдийн мэдээлэл:

Д.д	Хувьцаа эзэмшигчийн овог, нэр	Эзэмшиж байгаа хувьцааны тоо	Эзлэх хувь
1	Сүрэнжавын Пүрэв	377,660	70.00%
2	Монгол Улсын хуулийн этгээд “Селус Номадс” ХХК	102,390	18.98%

8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлт (2019 оны 4-р улирлын байдлаар)

8.1. Санхүүгийн үндсэн үзүүлэлтүүд

Үнэт цаас гаргагч нь 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлан, орлого үр дүнгийн тайланг 2019.01.01-с 2019.12.31-ний тайлант хугацаанд өссөн дүнгээр Монгол улсад мөрдөгдөж байгаа хууль тогтоомж заавар журам, нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэж тайлан хүлээн авах эрх бүхий газруудад хуулийн хугацаанд хүргүүлэн ажилласан. Хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид нь “Хархорин” ХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай Монголын хөрөнгийн биржийн цахим хуудаснаас танилцах боломжтой.

“Хархорин” ХК-ийн 2019 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлангийн дагуу нийт хөрөнгө 7,896.2 сая.төг болсон. Энэ нь өнгөрсөн оны мөн үеийн үзүүлэлт болох 7,721.9 сая.төг-с 2.2%-р өссөн үзүүлэлт юм.

2019 оны жилийн эцсийн байдлаар нийт үндсэн хөрөнгө 1,891.9 сая төгрөг, түүнчлэн биологийн хөрөнгө 1,082.8 сая. төгрөг болж эргэлтийн бус хөрөнгийн дүн 2,974.7 сая төгрөг болсон.

2019 оны жилийн эцсээр мөнгөн ба түүнтэй адилтгах хөрөнгө 1,382 мян.төг, авлагын нийт дүн 595,131 мян. төг, бараа материал нийт 391,668 мян.төг, бусад санхүүгийн хөрөнгө 1,296,918 мян.төг, бусад эргэлтийн хөрөнгө 2,636,360 мян.төг болж эргэлтийн хөрөнгийн дүн 4,921,459 мян. төгрөг болсон.

Урт болон богино хугацаат өр төлбөрийн хувьд 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дагуу “Хархорин” ХК нь нийт 70,000.0 мян.төг-ийн урт хугацаат зээлийн үлдэгдэлтэй, богино хугацаат өр төлбөр 8,526,418 мян.төг, нийт 8,596,418 мян.төг-ийн өр төлбөртэй гэж гарсан.


Үр дүнгийн тооцоо

Тайлант хугацаанд:	Борлуулалтын нийт орлого:	887,638 мян.төг
	Борлуулалтын өртөг:	866,851 мян.төг
	Борлуулалтын ашиг:	20,786 мян.төг
	Үйл ажиллагааны бус орлого:	59,042 мян.төг
	Ерөнхий ба удирдлагын зардал:	182,667 мян.төг
	Бусад зардал:	44,186 мян.төг

болж тайлант үеийн цэвэр ашиг татвар төлөхийн өмнөх байдлаар хасах 147,026 мян.төг болсон. Үүнээс орлогын албан татварын зардал 0.0 гэж үзвэл, тайлант үеийн алдагдал татварын дараах дүнгээр 147,026 мян.төг болно.

8.2. “Хархорин” ХК-ийн жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийн тухай

Компани нь Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй аудитын компани болох “Улиастай Ван Аудит” ХХК аудитын компаниар өөрийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлгэсэн болно.

 **“УЛИАСТАЙ ВАН АУДИТ” ХХК**
Аудит, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн зөвлөгөө, бүртгэлийн программ,
сургалтын итгэмжлэгдсэн байгууллага

2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр
Дугаар 100/2020

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

**“ХАРХОРИН” ХК-ийн
УДИРДАГАД**

Бид “Хархорин” ХК-ийн (шашид “Компани” гэх) 2019 оны 12 дугаар сарын 31-ны санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болгосон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн бодлогуудад аудит хийлээ.


Санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын хариуцлага
Эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэж, толилуулах нь компанийн удирдлагын үүрэг болно. Энэхүү үүрэг хариуцлагад санхүүгийн тайлангуудыг залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийлэлгүйгээр бэлтгэж, шударгаар толилуулахтай холбоотой дотоод хяналтын системийг зохиож, хэрэгжүүлж, түүнийгээ тууштай ажиллуулах, нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогуудыг сонгож, хэрэглэх, нөхцөл байдалд тохируулан нягтлан бодох бүртгэлийн тооцоолуудыг хийх зэрэг зүйлс багтана.

Аудиторын үүрэг хариуцлага
Бидний үүрэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах явдал юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэлээ. Эдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудыг баримталж, санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаардаг. Аудитын үед санхүүгийн тайлангууд дахь дүн болон тодруулгын талаар аудитын нотолгоо олж авахад чиглэгдсэн горимуудыг гүйцэтгэсэн. Эдгээр горимуудыг аудитормын шийдэлд суурилан сонгосон бөгөөд үүнд, залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийлэлийн эрсдлийн тооцоолол багтдаг. Эдгээр эрсдлийн тооцоололыг хийхтэй холбоотойгоор аудитор компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд нь дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг сонгож хэрэглэх зорилгоор компанийн санхүүгийн тайланг бэлтгэж, шударгаар толилуулахад зориулан хэрэглэж байгаа дотоод хяналтыг авч үздэг. Мөн санхүүгийн тайлагналыг бүрэлд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн томоохон тооцоолуудын үндэслэлтэй байдал, хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын тохиромжтой байдлыг үнэлэх ажлыг бидний аудит багтаасан. Бидний гүйцэтгэсэн аудит нь аудитын дүгнэлт хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоогоор хангагдсан гэж бид итгэж байна.

Дүгнэлтийн үндэслэл
Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага хэсэгт тайлбарласан. Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЕЗОУСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигдах ёс зүйн шаардлагын дагуу Бид компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЕЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигдаж ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэдэгт найдаж байна.

Хэрэглээний хязгаарлалт
Энэхүү тайлан нь Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох хувьцаа эзэмшигчийн хүсэлтийн дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан ба аливаа нэг өөр зорилго агуулаагүй болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бусад этгээдийн өмнө үүрэг хариуцлага хүлээхгүй болно.

Бусад хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаарх тайлан
Түүнчлэн, санхүүгийн тайлан бэлтгэхдээ Монгол улсад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн зарчмууд болон Сангийн сөлийн багтаан нягтлан бодох бүртгэлийн журам, заавартай нийцэж байна


“УЛИАСТАЙ ВАН АУДИТ” ХХК

Чингэлтэй дүүрэг, 3-р хороо
Улиастайны өргөн чөлөө
CANON тов, 6 давхар, 602 тоот
Улаанбаатар Монгол улс

Утас: 76007405, 99097405, 70157405
И-мэйл хаяг: uliastai.van.audit@ubaudit.mn
Веб хуудас: ubaudit.mn


УЛИАСТАЙ ВАН АУДИТ ХХК
Page 02

Зураг 1. Хараат бус аудитормын дүгнэлт

“ХАРХОРИН” ХК
АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрхи

		(мянган төгрөг)	
		<u>2018.12.31</u>	<u>2019.12.31</u>
Хөрөнгө			
Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлс	4	1,897	1,382
Дансны авлага	5	903,269	540,692
Бусад авлага	6	268,650	54,439
Бусад санхүүгийн хөрөнгө	7	1,296,918	1,296,918
Бараа материал	8	425,494	391,668
Бусад эргэлтийн хөрөнгө	9	2,095,102	2,636,360
Үндсэн хөрөнгө	10	1,647,844	1,891,916
Биологийн хөрөнгө	11	1,082,788	1,082,788
Нийт хөрөнгийн дүн		<u>7,721,961</u>	<u>7,896,163</u>
Өр төлбөр			
Богино хугацаат өр төлбөр			
Дансны өглөг	12	6,089,839	6,718,914
Цалингийн өглөг	12	92,906	135,242
Татварын өр	12	11,558	22,405
НДШ-ийн өглөг	12	11,718	18,233
Богино хугацаат зээл	12	1,015,753	1,088,047
Хүүний өглөг	12	380,036	543,577
Богино хугацаат өр төлбөрийн дүн		<u>7,601,811</u>	<u>8,526,418</u>
Урт хугацаат өр төлбөр			
Урт хугацаат зээл	13	673,380	70,000
Урт хугацаат өр төлбөрийн дүн		<u>673,380</u>	<u>70,000</u>
Өр төлбөрийн нийт дүн		<u>8,275,191</u>	<u>8,596,418</u>
Эзэмшигчдийн өмч			
Өмч /хувийн/	14	836,220	836,220
Хуримтлагдсан ашиг алдагдал	15	(1,389,450)	(1,536,476)
Эзэмшигчдийн өмчийн дүн		<u>(553,230)</u>	<u>(700,255)</u>
Өр төлбөр эзэмшигчдийн өмчийн дүн		<u>7,721,961</u>	<u>7,896,163</u>

Санхүүгийн тайлангийн санхүүг хэсэг байна.


 ОЗ


Зураг 2. “Хархорин” ХК-ийн 2018 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн байдлын тайлан

“ХАРХОРИН” ХК
 АУДИТЛАГДСАН ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН
 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

(минган төгрөг)

	2018.12.31	2019.12.31
Борлуулалтын орлого	16 1,362,445	887,638
Борлуулалтын өртөг	17 1,336,367	866,851
Нийт ашиг, (алдагдал)	26,079	20,786
Бусад орлого	18 90,575	59,042
Ерөнхий ба удирдлагын зардал	19 178,915	182,667
Бусад зардал	18 48,669	44,186
Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал	(110,930)	(147,026)
Орлогын албан татварын зардал	-	-
Татварын дараах ашиг, алдагдал	(110,930)	(147,026)
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	(110,930)	(147,026)
Цэвэр ашиг (алдагдал)	(110,930)	(147,026)

Саягуулийн мөнгөнийг салхгүй хэсэг болно.



Зураг 3. “Хархорин” ХК-ийн 2018 оны жилийн эцсийн аудитлагдсан орлогын тайлан

“ХАРХОРИН” ХК
АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

				(мянган төгрөг)
	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Өмчийн дүн
2017 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	836,220		(1,389,450)	(553,230)
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Залруулсан үлдэгдэл	836,220		(1,389,450)	(553,230)
Бусад дэлгэрэнгүй орлого				-
Өмчид гарсан өөрчлөлт				-
Тайлангийн үеийн цэвэр ашиг (алдагдал)				-
Хуваарилсан ногдол ашиг				-
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг				-
2018 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	836,220		(1,389,450)	(553,230)
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Залруулсан үлдэгдэл	836,220		(1,389,450)	(553,230)
Бусад дэлгэрэнгүй орлого				-
Тайлангийн үеийн цэвэр ашиг (алдагдал)			(147,026)	(147,026)
Зарласан ногдол ашиг				-
Өмчид гарсан өөрчлөлт				-
2019 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	836,220		(1,536,476)	(700,255)

Саягуугийн тайлангийн санхүүг хэсэг болно.

Page: 05

Зураг 4. “Хархорин” ХК-ийн 2018 оны жилийн эцсийн аудитлагдсан өмчийн өөрчлөлтийн тайлан

“ХАРХОРИН” ХК
 АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

	(мянган төгрөг)	
	2018.12.31	2019.12.31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	2,750,270	1,937,147
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	29,174	718,299
Бусад орлого	2,721,097	1,218,848
Мөнгөн зарлагын дүн	2,750,451	1,937,662
Ажигчдад төлсөн	313,318	199,386
НД-ийн байгууллагад төлсөн	123,973	88,698
Бараа материал худалдан авахад төлсөн	6,464	10,190
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	13,152	9,995
Түлш шатахуун, тээврийн хөлөг, сэлбэг хэрэгсэд төлсөн мөнгө	50,362	91,523
Хүүний төлбөрт төлсөн мөнгө	183,154	155,244
Татварын байгууллагад төлсөн мөнгө	54,142	27,437
Бусад мөнгөн зарлага	2,005,887	1,355,189
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(180)	(515)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	-	-
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
Биег бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
Мөнгөн зарлагын дүн	-	-
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Биег бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	-	-
Эзэл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
Хувицаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
Мөнгөн зарлагын дүн	-	-
Эзэл, өрийн үнэт цаас төлбөрт төлсөн мөнгө	-	-
Санхүүгийн түүрээсийн өглөгт төлсөн	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
Валютын ханшийн зөрүү	-	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(180)	(515)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,077	1,897
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эсний үлдэгдэл	1,897	1,382

Санхүүгийн мөнгөн гүйлгээний тухай мэдээлэл

06

Зураг 5. “Хархорин” ХК-ийн 2018 оны жилийн эцсийн аудитлагдсан мөнгөн гүйлгээний тайлан

8.3. Татварын тайлангийн тухай (2019 оны жилийн эцсийн байдлаар):

“Хархорин” ХК нь 2019 оны 01-с 04-р улирлын татварын тайлангуудаа Монгол улсын Татварын багц хууль, тогтоомж, заавар журмын дагуу хуулийн хугацаанд гаргаж цахимаар харъяа татварын байгууллагад цаг хугацаанд нь илгээж баталгаажуулсан болно.

9. Компанийн тухай хуульд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээлэл

Тайлант хугацаанд “Хархорин” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс 2019 оны 04 сарын 12 өдрийн хурлаараа “Хархорин чацаргана” ХХК-ийн УБ хотын банкнаас авах 3,348,000 мянган төгрөгийн зээлд батлан даалт гаргах, тус зээлийн барьцаанд УБ хотын банкинд барьцаалсан байгаа хөрөнгөнүүдийг давхар барьцаалах зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Тус шийдвэрийг Монгол Улсын Компанийн тухай хуульд заасан журмын дагуу ТУЗ-ийн гишүүд хуралдаж санал нэгтэй гаргасан болно. Түүнчлэн “Ди Би Эм Лизинг” ХХК-с лизингийн нөхцөлөөр дуслын усалгааны систем худалдан авах хэлцэл нь Компанийн тухай хуулийн дагуу их хэмжээний хэлцэлд тооцогдохоор байсан боловч хэлцэл хийгдэх эсэх нь тус лизингийн байгууллагатай холбоотой шалтгаанаар өдийг хүртэл шийдэгдээгүй байна.

10. Үнэт цаас гаргагчийн 2019 онд хийж гүйцэтгэсэн ажлын талаарх мэдээлэл

“Хархорин” ХК-ний 2019 оны агро үйлдвэрлэлийн тайлан

Нэг. “Хархорин” ХК-ний агроүйлдвэрлэлийн талбайн байгаль цаг уурын онцлог

“Хархорин” ХК-ны 4200 га хэмжээ бүхий агро үйлдвэрлэлийн талбай нь Өвөрхангай аймгийн Хархорин сумын төвөөс зүүн зүгт оршдог ба талбайн баруун урдаас Орхон голын их хөндий эхлэдэг тул голоо дагаж салхилах өлийн салхи, голоо өгсөж салхилах хойд салхи гэсэн орон нутгийн чанартай эх газрын хоёр салхины уулзвар болдог. Энэ нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд муугаар нөлөөлдөг цаг уурын огцом өөрчлөлтүүд болох мөндөр орох, шороон болон цасан шуурга шуурах, хавартаа сүүлдэж, намартаа эрт цочир хүйтрэлт болох, хяруу унах, ган гачиг болох зэрэг байгалийн бэрхшээлүүд ихээр тохиолдох магадлалыг ихэсгэдэг.

2018 – 2019 оны өвөл манай талбайд маш бага хэмжээний цастай буюу 1 - 2 см орчим зузаан цастай өвөлжсөн. Гэвч хавар 3-р сарын 19-нд 12 см зузаан цас ороод 25-нд буюу 7 хоноод бүрэн хайлсан нь талбайд нилээд их чийг өгсөн. 3-р сарын 26, 3-р сарын 29, 4-р сарын 6, 4-р сарын 24 хүртэл дөрвөн удаа нэмэх 12⁰С –ээс хасах -14⁰С хүртэлх хэм хүртэл огцом хүйтэрч хэт бага буюу 0,1-0,2 мм зузаантай цас орсон. 5-р сарын 4, 11, 14, 17-нд буюу нийтдээ дөрвөн удаа нэмэх 21⁰С –ээс хасах -8⁰С хүртэлх хэм хүртэл огцом хүйтэрч, нилээд хэмжээний буюу 3 – 12 орчим см зузаантай цас орсон нь хөрсөнд тодорхой хэмжээний чийг өгсөн. Гэвч цаашдаа бага боловч бороо цас орж чийг өгөлгүйгээр 6-р сарын дунд үе хүртэл үргэлжилсэн хаврын агаарын ган болсон. Дээрх олон удаагийн огцом хүйтрэлтүүд, хаврын агаарын ган зэргээс шалтгаалан энэ жил чацарганы жимст цэцэрлэгт чацарганы болон бусад жимст модлог ургамлуудад жимс дундаас арай бага хэмжээтэй суусан. Хэдийгээр зундаа хур бороо элбэгтэй байсан ч хавар чацарганы болон бусад жимслэгч моддын ид цэцэглэлтийн үед олон удаа цочмог ихээр хүйтэрсэн, чийг нилээд дутмаг байсан нь энэ оны жимсний ургац бага байгаатай зайлшгүй холбоотой юм.

Хавар 4-р сарын эхний 10 хоногт чацарганы модны нахиа задарч эхлэдэг байхад энэ жил 4-р сарын 20-нд эхний нахиа дөнгөж задарч эхлэсэн нь хаврын цочир хүйтрэлт болон хаврын чийгийн дутагдалтай холбоотой юм.

3, 4-р саруудад маш бага хэмжээтэй цас орж, огцом хүйтэрч байсан нь шуудуу ухалт, суулгац гаргалт, талбайн усалгааны зэрэг ажлуудад нилээд бэрхшээл учруулж байв. Мөн 5-р сарын 20-нд хөрсөн дээр шөнөдөө -9 -аас -11 °C хүрч хүйтэрсэн ба энэ үед услах, утаа май тавих зэрэг хамгаалах арга хэмжээ хэдийгээр авсан боловч хөрс ба агаарын хэт хүйтэнд үхэр нүд, далан хальс, алим зэрэг жимст модлог ургамлуудын цэцэг нийлэнхүйдээ хөлдөж, гөвөгдөж унаснаас шалтгаалан дээрх ургамлууд бараг жимслээгүй.

6-р сарын эхээр жил бүр их багаар гарч ирдэг хортон шавьжууд энэ жил жимст цэцэрлэгийн талбайд бараг гараагүй нь хавар олон удаа огцом хүйтэрч байсантай шууд холбоотой нь тогтоогдсон.

6-р сарын 15-нд 0,5 – 0,7 см хэмжээтэй мөндөр 20 гаран минутын турш орсон боловч манай жимст цэцэрлэгийн болон тариалангийн талбайд үзүүр нь дайрч өнгөрөн харьцангуй бага нөлөөлсөн.

Гэвч 6-р сарын сүүлчээр буюу 6-р сарын 30-нд 0,6 см хэмжээтэй мөндөр бүхий их хүчтэй аадар бороо 20 минутын турш, мөн 7-р сарын 4-нд их хэмжээний устай аадар бороо бас 15 минутын турш орсон ба энэ 2 удаагийн борооноос шалтгаалж маш хүчтэй үер мөн хоёр удаа бууснаас манай шуудуунд их хэмжээний шавар шороо орж талбайн усалгаа 14 орчим хоног саатсан. Мөн 8-р сарын 5-нд их хэмжээний усархаг аадар бороо орсноос болж дахин үер болж манай шуудуунд үерийн шавар шороо орсноос шалтгаалан усалгаа дахин 14 хоног саатсан зэрэг нь 7-р сарын эхнээс 8-р сарын дунд үе хүртэл үерээс шалтгаалж талбайг услах боломжгүй байсан нь чацарганы жимсний ургалтанд муугаар нөлөөлсөн.

Намар 9-р сарын 5-нд $\Phi=1,2$ см хэмжээтэй мөндөр бүхий аадар бороо 14 минутын турш орсон боловч жимст цэцэрлэгийн талбайд үзүүр нь хальт дайрч өнгөрсөн учир харьцангуй бага хор нөлөө учруулсан.

Намар 9-р сарын 28-нд сибириэс нүүж ирэн чацаргана жимсний ургацанд маш их хор хохирол учруулдаг алагтуу, хар тодол, турлиах шувууд нүүж ирэн жимсний ургацанд их хэмжээний хохирол учруулж эхэлсэн. Намар 10-р сард нилээд хэмжээний цас орж хэсэг хүйтрээд цаашдаа 11, 12-р сард дулаахан байсан.

Хоёр. Хаврын ажлын талаар

2.1. Шуудуу цэвэрлэгээний ажлын талаар

Усалгааны төв цементэн сувгийн ёроолд өнгөрсөн зуны борооны үерийн үеээр орсон зузаан лаг, шаврын зузаан хэсгийг техникээр хусаж аваад, гүехэн хэсгийг нийт бригадуудын ажилчдын хүчээр цэвэрлээд сувгийн усыг тавьсан.

4-р сарын 2-ны өдрөөс эхлэн нийт жимст цэцэрлэг хариуцсан цэцэрлэгчдийн хүчээр суваг цэвэрлэх ажил эхэлсэн. Сумын төвийн дундуур урсдаг төв сувгийн ёроолын шавар шороог гараар цэвэрлэх ажил 4-р сарын 21-ний өдөр хүртэл буюу нийтдээ 13 хоног үргэлжилсэн. Энэ ажилд 1-р бригадын 8 цэцэрлэгчийн 39 хүн/өдөр хүчээр 122,4 м³ сувгийн шавар шороог сувгийн ёроолоос ухаж гаргаад, 6 хүн/өдөр хүчээр сумын төвийн дундуур гардаг сувгийн хэсгээс сувгийн шавар шороог тракторын чиргүүл, самосвалд ачиж хогийн цэг дээр аваачиж буулгаж асгасан. 2-р бригадын 8 цэцэрлэгчийн 37,5 хүн/өдөр хүчээр 112 м³ сувгийн шавар шороог сувгийн ёроолоос ухаж гаргасан. 3-р бригадын 6 цэцэрлэгчийн 37,5 хүн/өдөр хүчээр 119,5 м³ сувгийн шавар шороог сувгийн ёроолоос ухаж гаргаад, 3 хүн/өдөр хүчээр сумын төвийн дундуур гардаг сувгийн хэсгээс сувгийн шавар шороог тракторын чиргүүл, самосвалд ачиж хогийн цэг дээр аваачиж буулгаж асгасан. 4-р

бригадын 7 цэцэрлэгчийн 44,5 хүн/өдөр хүчээр 113,8 м³ сувгийн шавар шороог сувгийн ёроолоос ухаж гаргаад, 3 хүн/өдөр хүчээр сумын төвийн дундуур гардаг сувгийн хэсгээс сувгийн шавар шороог тракторын чиргүүл, самосвалд ачиж хогийн цэг дээр аваачиж буулгаж асгасан. Нийт дүнгээрээ компаний агроүйлдвэрлэлийн 4 бригадын 29 цэцэрлэгчдийн 158,5 хүн/өдөр хүчээр 467,7 м³ сувгийн шавар шороог сувгийн ёроолоос ухаж гаргаад, 12 хүн/өдөр хүчээр сумын төвийн дундуур гардаг сувгийн хэсгээс сувгийн шавар шороог тракторын чиргүүл, самосвалд ачиж хогийн цэг дээр аваачиж буулгаж асгасан.

3-р сарын 29-с 4-р сарын 22 хүртэлх хугацаанд усалгааны төв сувгийг компаний болон түрээсийн техникүүдээр цэвэрлэх ажил хийгдсэн бөгөөд уг ажилд түрдэг манай компаний ДТ-75 трактор, эксковатор, ковш болон түрээсийн эксковатор зэргийг ашиглаж хийж гүйцэтгэсэн.

4-р сарын 20-нд сувагт ус өгч эхлэсэн ба 21-25-нд усалгааны газар доорх төв системээр ус урсган угаагаад, 25-ны шөнө системийн төв шугамуудыг усаар дүүргээд 26-с эхлэн бойжуулгын талбайн тариалалт, усалгаа эхлэсэн.

2.2. Хавар болон намар суулгац гаргаж нийлүүлсэн талаар

Энэ жилийн хавар болон намар гаргасан чацаргана ба бусад модлог ургамлын суулгацын нийт хөдөлгөөнийг дараах хүснэгтэнд гаргаж үзүүлэв.

Хүснэгт 1: Гадагш ба дотоодод (нөхөн тариалалт) гаргасан суулгацын хөдөлгөөн

Үзүүлэлт	Суулгацын төрөл (11), тоо (ширхэгээр)															Нийлүүлсэн нийт тоо
	Чацаргана			Үхэр нүд	У лиас	Хай-лаас	Бөөрөлзгөнө	Шар хуайс	Гү-зээлз- гэнэ	Мо нос	Далан хальс	Бургас	Улаалзгана	Нохойн хошуу	Гүйлс	
	Эр	эм	Нийт													
Хаврын дүн	9,986	96,211	106,197	767	2,332	21,663	215	17	66	82	13	15	56	36	82	131,532
Намрын дүн	397	3,561	3,958	712	450	114	311	100	0	13	0	0	3	0	0	5,661
ОНЫ БҮХ ДҮН	10,383	99,772	110,155	1,479	2,782	21,777	526	117	66	95	13	15	59	36	82	137,193

4-р сард чацарганы 1277 ширхэг, улиасны 3 ширхэг, хайлаасны 7692 ширхэг, үхэр нүдний 12 ширхэг, моносны 12 ширхэг, бөөрөлзгөний 3 ширхэг, гүзээлзгэний 14 ширхэг, чимэглэлийн нохойн хошууны 4 ширхэг, улаалзганы 4 ширхэг суулгацуудыг бойжуулгын талбайгаас ухаж гарган гадагш ба дотооддоо нөхөн тариалалтанд нийлүүлсэн.

5-р сард чацарганы 75045 ширхэг, улиасны 2329 ширхэг, хайлаасны 11427 ширхэг, үхэр нүдний 755 ширхэг, моносны 70 ширхэг, бөөрөлзгөний 183 ширхэг, гүзээлзгэний 1 ширхэг, чимэглэлийн нохойн хошууны 22 ширхэг, далан хальсны 13 ширхэг, гүйлсний 82 ширхэг, улаалзганы 42 ширхэг, бургасны 15 ширхэг суулгацуудыг, ойн зурвасаас 17 ширхэг шархуайсны бут зэргийг бойжуулгын талбайгаас ухаж гарган гадагш ба дотооддоо нөхөн тариалалтанд нийлүүлсэн.

6-р сард хайлаасны 110 ширхэг, бөөрөлзгөний 20 ширхэг, гүзээлзгэний 51 ширхэг зэрэг суулгацуудыг бойжуулгын талбайгаас ухаж гарган гадагш ба дотооддоо нөхөн тариалалтанд нийлүүлсэн.

4-р сард бойжуулгын талбайгаас ковшоор суулгац ухаж гаргаад ажилчидын хүчээр талбайгаас түүж, ялгаж, тоолж, боож багцлан гадагшаа ба дотооддоо нөхөн тариалалтанд

нийлүүлсэн. Энэхүү ажилд 1-р бригадын 7 цэцэрлэгчийн 7 хүн/өдөр хүчийг, 2-р бригадын 11 цэцэрлэгчийн 10,5 хүн/өдөр хүчийг, 3-р бригадын 6 цэцэрлэгчийн 3 хүн/өдөр хүчийг, 4-р бригадын 9 цэцэрлэгчийн 8,6 хүн/өдөр хүчийг буюу нийтдээ бригадуудын 33 цэцэрлэгчийн 29,1 хүн/өдөр хүчийг зарцуулсан.

5-р сард бойжуулгын талбайгаас ковшоор суулгац ухаж гаргаад ажилчидын хүчээр талбайгаас түүж, ялгаж, тоолж, боож багцлан гадагшаа ба дотооддоо нөхөн тариалалтанд нийлүүлсэн. Энэхүү ажилд 1-р бригадын 8 цэцэрлэгчийн 42,3 хүн/өдөр хүчийг, 2-р бригадын 12 цэцэрлэгчийн 82,7 хүн/өдөр хүчийг, 3-р бригадын 7 цэцэрлэгчийн 28 хүн/өдөр хүчийг, 4-р бригадын 9 цэцэрлэгчийн 65 хүн/өдөр хүчийг буюу нийтдээ бригадуудын 36 цэцэрлэгчийн 192 хүн/өдөр хүчийг зарцуулсан.

Мөн 6-р сард тус 2-р бригадын 9 цэцэрлэгчийн 1,9 хүн/өдөр хүчээр гадагш ба дотоодын нөхөн тариалалтын суулгацууд гаргах зэрэг ажлуудыг хийлгэсэн.

Суулгац гаргахад бригадуудаас хавар ба намар хүн хүч татаж аван, ухаж гаргах, тоолж боох, ачих ажилд дайчилсан.

Суулгац ухаж гаргах хайрцгуудыг услахдаа бойжуулгын 2-р бригадын хүн хүчээр хайрцагны усалгаа хийлгэсэн.

Хавар хамгийн сүүлд бөөрөлзгөнө, гүзээлзгэнэ, хайлаасны суулгацуудыг 6-р сарын 18 хүртэлх хугацаанд ухаж гадагш нийлүүлсэн.

Намрын суулгац гаргалтын ажил нийлээд орой буюу 10-р сарын 12-оос суулгац гаргалт эхлээд 21-нд суулгац гаргалт зогссон.

10-р сард бойжуулгын талбай хариуцсан 2-р бригадын 6 цэцэрлэгчийн 6 хүн/өдөр хүчээр энэ намар суулгацыг нь ухаж гадагш ба дотооддоо нийлүүлэх суулгацууд бүхий 266 хайрцгийг сувгаар услуулан.

10-р сард 1-р бригадын 4 цэцэрлэгчийн 5,5 хүн/өдөр хүчээр, 2-р бригадын 7 цэцэрлэгчийн 18,6 хүн/өдөр хүчээр, 3-р бригадын 4 цэцэрлэгчийн 7 хүн/өдөр хүчээр, 4-р бригадын 5 цэцэрлэгчийн 7,5 хүн/өдөр хүчээр буюу нийтдээ “Хархорин” ХК-ийн агроүйлдвэрлэлийн дөрвөн бригадын 20 цэцэрлэгчийн 38,6 хүн/өдөр хүчээр бойжуулгын талбайгаас ковшоор ухаж гаргасан чацаргана болон бусад модлог ургамлын суулгацыг түүж аван боолт хийж буй газарт аваачиж өгөх, авчирсан суулгацыг түр хадгалалтанд прикоплож хадгалах, түр хадгалалтаас ухаж гаргах, гаргасан суулгацыг зэрэглэн ялган, тоолж, шошго зүүгээд багцлан боож, ачиж явуулах, гологдол суулгацыг бойжуулгын талбайд буцааж тариалуулах зэрэг ажил хийлгэсэн.

Нийт дүнгээрээ энэ жил 110,155 ш чацарганы, 1479 ш үхэр нүдний, 2782 ш улиасны, 21,777 ш хайлаасны, 526 ш бөөрөлзгөний, 117 ш шар хуайсны, 66 ш гүзээлзгэний, моносны 95 ш, далан хальсны 13 ш, бургасны 15ш, улаалзганы 59 ш, нохойн хошууны 36 ш, гүйлсний 82 суулгац буюу жилийн нийт дүнгээр 137,193 ш суулгац ухаж гарган дотооддоо нөхөн тариалалтанд ба гадагшаа тараан олгосон.

Мөн намар 10-р сард ковшоор суулгац гаргах үед үндэс нь тасарч, шалбарч гэмтсэн гологдол суулгацуудыг бойжуулгын талбайд буцааж тариалж услуулан.

2.3. Хавар талбайд хийгдсэн ажлын талаар

2019 оны 03 сарын 25-ны өдөр компанийн бүх ажилчидын хурал хийж энэ оны ажлын төлөвлөгөөг танилцуулснаар энэ жилийн ажил эхлэсэн. Мөн өдөр агрономчид, ЗАА-н ажилчидын хүчээр жимст цэцэрлэгийн талбайд тархсан хортон мэрэгчидийн эсрэг тэмцэх бромадиолонтой будаагаар хорт өгөөш бэлтгэж найруулах ажил эхлэсэн. 3-р сарын 26-ны өдрөөс эхлэн 6 хоногийн хугацаанд нийт жимст цэцэрлэгийн талбайд хортон мэрэгчидийн эсрэг хорт өгөөшийг мэрэгчидийн үүрний амсар, байнга явдаг жим зам дээр тавих ажил хийгдсэн. Энэ ажилд жимст цэцэрлэг

хариуцсан бригадуудын нийт цэцэрлэгчид дараах байдлаар ажилласан болно. Үүнд: Г.Маргад-Эрдэнэ агрономчтой 1-р бригадын 4 цэцэрлэгчийн 16 хүн/өдөр хүчээр 46,5 га жимст цэцэрлэгийн талбайд, Б.Мэнддолгор агрономчтой 2-р бригадын 6 цэцэрлэгчийн 11 хүн/өдөр хүчээр 33 га жимст цэцэрлэгийн талбайд, 3-р бригадын 5 цэцэрлэгчийн 19 хүн/өдөр хүчээр 57 га жимст цэцэрлэгийн талбайд, 4-р бригадын 4 цэцэрлэгчийн 17 хүн/өдөр хүчээр 51 га жимст цэцэрлэгийн талбайд буюу нийт дүнгээрээ агроүйлдвэрлэлийн 4-н бригадын 19 цэцэрлэгчдийн 63 хүн/өдөр хүчээр 187,5 га жимст цэцэрлэгийн талбайд хортон мэрэгчидийн эсрэг хорт өгөөш тавьж тэмцсэн.

3-р сарын 31-ний өдөр нийт жимст цэцэрлэг хариуцсан бригадын цэцэрлэгчдийн хүчээр жимст цэцэрлэгийн талбайд талбайн хогийг цэвэрлэсэн ба энэ ажилд 1-р бригадын 4 цэцэрлэгчийн 4 хүн/өдөр хүчийг, 2-р бригадын 3 цэцэрлэгчийн 6 хүн/өдөр хүчийг, 3-р бригадын 3 цэцэрлэгчийн 1,5 хүн/өдөр хүчийг, 4-р бригадын 5 цэцэрлэгчийн 5 хүн/өдөр хүчийг буюу нийт дүнгээрээ агроүйлдвэрлэлийн 4-н бригадын 15 цэцэрлэгчдийн 16,5 хүн/өдөр хүчийг ашигласан.

4-р сард 3-р бригадын нэг цэцэрлэгчийн 14,7 хүн/өдөр хүчээр компаний аж ахуйн хашаанд байрлах 2 дарлаганд тариалсан хэмхний үрслэгний усалгаа, арчилгааны ажлыг хийлгэсэн.

5-р сард 3-р бригадын нэг цэцэрлэгчийн 8,8 хүн/өдөр хүчээр дарлаганы усалгаа хийх, 3 хүн/өдөр хүчээр дарлаганд тариалсан хэмхний үрслэгийг шороолох, 1,8 хүн/өдөр хүчээр дарлаганы хэмхний үрслэгийн завсраар ургасан зэрлэг хог ургамлыг гараар сугалж устгах, 17,4 хүн/өдөр хүчээр өглөө дарлаганы эсгий хучлагыг сөхөж нарлуулаад, орой нь дарлагыг эсгий хучлагаар буцааж хучих зэрэг компаний аж ахуйн хашаанд байрлах 2 дарлаганд тариалсан хэмхний үрслэгний арчилгааны ажлуудыг хийлгэсэн.

5-р сард жимст цэцэрлэгийн чацарганы модонд тоос хүртээх, жимст цэцэрлэгийн чацарганы модонд тоос хүртээхэд зориулж хөгширч актлагдсан эр модны суулгацаас тоос хүртээх мөчир хайчлан тоос хүртээлт хийж буй бригадуудад нийлүүлэх, үхэр нүдний талбайн хярууны хамгаалалтанд бэлтгэх, хярууны хамгаалалтанд гарах, гадагш нийлүүлэх суулгацыг түр хадгалалтаас ухаж гарган ялган тоолж ангилаад, шошго зүүн боож ачих, оросын олон төрлийн модны хучлага авах, усалгаа хийх шуудууг нь сэргээн засах, усалгаа хийх, тракторт чиг татаж зогсох зэрэг цагийн ажилд 1-р бригадын 8 цэцэрлэгчийн 46,4 хүн/өдөр хүч, 2-р бригадын 11 цэцэрлэгчийн 36,1 хүн/өдөр хүч, 3-р бригадын 6 цэцэрлэгчийн 51,4 хүн/өдөр хүч, 4-р бригадын 9 цэцэрлэгчийн 45 хүн/өдөр хүч буюу нийт дүнгээрээ дөрвөн бригадын 34 цэцэрлэгчийн 178,9 хүн/өдөр хүч зарцуулсан.

5-р сард нийт бригадууд өөр өөрийн хариуцсан талбайн ойн зурвасыг нөхөн тариалсан ба энэ ажилд 1-р бригадын 7 цэцэрлэгчийн 1,4 хүн/өдөр хүчээр 90 модны нүх ухаад, мөн 1,4 хүн/өдөр хүчээр ухсан нүхэндээ улиасны суулгацаар тариалалт хийж, 0,7 хүн/өдөр хүчээр тариалсан моддыг тогоонд нь шуудуунаас хувингаар ус зөөж усалгаа хийлгэсэн. 2-р бригадын 9 цэцэрлэгчийн 2,1 хүн/өдөр хүчээр 170 модны нүх ухаад, мөн 10 цэцэрлэгчийн 1,7 хүн/өдөр хүчээр ухсан нүхэндээ улиасны суулгацаар тариалалт хийж, 11 цэцэрлэгчийн 2,3 хүн/өдөр хүчээр тариалсан 170 мододоо тогоонд нь шуудуунаас хувингаар ус зөөж усалгаа хийлгэсэн. 3-р бригадын 7 цэцэрлэгчийн 5,6 хүн/өдөр хүчээр 511 модны нүх ухаад, мөн 7 цэцэрлэгчийн 3,1 хүн/өдөр хүчээр улиасны суулгацаар тариалалт хийж, 3,2 хүн/өдөр хүчээр тариалсан мододоо тогоонд нь шуудуунаас хувингаар ус зөөж усалгаа хийлгэсэн. Нийт дүнгээрээ гурван бригадын 23 цэцэрлэгчийн 9,1 хүн/өдөр хүчээр ойн зурвасын 771 модны нүхийг ухаад, мөн 24 цэцэрлэгчийн 6,5 хүн/өдөр хүчээр 771 улиасны суулгацаар тариалалт хийж, 6,2 хүн/өдөр хүчээр тариалсан моддыг тогоонд нь шуудуунаас хувингаар ус зөөж усалгаа хийлгэсэн.

5-р сард 1-р бригадын 0,5 хүн/өдөр хүчээр 13Б жимст цэцэрлэгийн талбайнуудад нөхөн тариалалтын 400 ширхэг чацарганы модны нүх ухуулаад, мөн 1 цэцэрлэгчийн 0,5 хүн/өдөр хүчээр чацарганы нөхөн тариалалтын 100 ширхэг модыг нөхөн тариалсан ба энэхүү 13Б болон үхэр нүдний 19Б талбайнуудад мөн бригадын 8 цэцэрлэгчийн 33 хүн/өдөр хүчээр 38800 м урт усалгааны туслах

шуудуугаар усалгаа хийлгэсэн. 3-р бригадын 7 цэцэрлэгчийн 19 хүн/өдөр хүчээр 1А жимст цэцэрлэгийн талбайд нөхөн тариалалтын 7648 ширхэг чацарганы модны нүх ухуулаад, 7 цэцэрлэгчийн 17 хүн/өдөр хүчээр мөн талбайд чацарганы нөхөн тариалалтын 7648 ширхэг модыг нөхөн тариалж усалгааны туслах шуудуугаар усалгаа хийлгэсэн. Нийт дүнгээрээ хоёр бригадын 19,5 хүн/өдөр хүчээр жимст цэцэрлэгийн 1А, 13Б талбайнуудад нөхөн тариалалтын 8048 ширхэг чацарганы модны нүх ухуулаад, мөн 8 цэцэрлэгчийн 17,5 хүн/өдөр хүчээр чацарганы нөхөн тариалалтын 7748 ширхэг модыг нөхөн тариалаад эдгээр талбайнуудад усалгааны туслах шуудуугаар усалгаа хийлгэсэн.

Мөн 5-р сард Хархорин-Чацаргана ХХК-ны Ротаригийн хүлэмжний шилмүүст модны суулгац тариалсан хүлэмжүүдийн үртсэн хучлага авах, хүлэмжийг буцааж торон ба плёнкон хучлагаар хучих, хэмх тариалах хүлэмжүүдэд хэмх тариалах хамар хийх, усалгааны нуурыг цэвэрлэх зэрэг цагийн ажлуудад 1-р бригадын 7 цэцэрлэгчийн 7 хүн/өдөр хүчийг, 4-р бригадын 9 цэцэрлэгчийн 17 хүн/өдөр хүчийг буюу нийтдээ хоёр бригадын 16 цэцэрлэгчийн 24 хүн/өдөр хүчийг зарцуулсан.

5-р сард 2-р бригадын 11 цэцэрлэгчийн 7,5 хүн/өдөр хүчээр оросын модны 10Б талбайд усалгааны туслах шуудуунуудыг нь шинээр сэргээн ухаж гаргаад, 3230 ширхэг модны тогоонд 25-40 литр усыг хувингаар тогоо уруу нь шуудуунаас усалгаа хийлгэсэн.

Мөн 5-р сард Хархорин-Чацаргана ХХК-ны Ротаригийн хүлэмжний шилмүүст модны суулгац тариалсан хүлэмжүүдийн үртсэн хучлага авах, хүлэмжийг буцааж торон ба плёнкон хучлагаар хучих, хэмх тариалах хүлэмжүүдэд хэмх тариалах хамар хийх, усалгааны нуурыг цэвэрлэх зэрэг цагийн ажлуудад 1-р бригадын 7 цэцэрлэгчийн 7 хүн/өдөр хүчийг, 4-р бригадын 9 цэцэрлэгчийн 17 хүн/өдөр хүчийг буюу нийтдээ хоёр бригадын 16 цэцэрлэгчийн 24 хүн/өдөр хүчийг зарцуулсан.

5-р сард 2-р бригадын 11 цэцэрлэгчийн 7,5 хүн/өдөр хүчээр оросын модны 10Б талбайд усалгааны туслах шуудуунуудыг нь шинээр сэргээн ухаж гаргаад, 3230 ширхэг модны тогоонд 25-40 литр усыг хувингаар тогоо уруу нь шуудуунаас усалгаа хийлгэсэн.

2.4. Хаврын бусад ажлын талаар

4-р сард ямаа самнах, Хархорин-ТУР-д үйлчилгээнд ажиллах, хөлдөөх агуулахыг цэвэрлэх зэрэг аж ахуйн ажилд 1-р бригадын 3 хүн/өдөр хүчээр, 2-р бригадын мөн 1 хүн/өдөр хүчээр, 3-р бригадын 2 хүн/өдөр хүчээр, 4-р бригадын 2 хүн/өдөр хүчээр буюу нийт дүнгээрээ бригадуудын 8 хүн/өдөр хүчээр аж ахуйн ажил хийлгэсэн.

4-р сарын 10–11-нд жимс хөлдөөх хөлдөөгчийн барилгын дотор хураалттай байсан “Хархорин-ШИМ” ХХК-ны тэжээлийн улаан буудайг дахин шуудайлж, савлан ачиж зөөн хураах ажилд нийт жимст цэцэрлэг хариуцсан бригадуудын хүн хүчийг ашигласан ба энэ ажилд 1-р бригадын 6 цэцэрлэгчийн 12 хүн/өдөр хүчийг, 2-р бригадын 5 цэцэрлэгчийн 6,5 хүн/өдөр хүчийг, 3-р бригадын 6 цэцэрлэгчийн 6 хүн/өдөр хүчийг, 4-р бригадын 5 цэцэрлэгчийн 9 хүн/өдөр хүчийг буюу агроүйлдвэрлэлийн 4 бригадын 22 цэцэрлэгчийн 33,5 хүн/өдөр хүчийг тус тус ашигласан.

Мөн 4-р сарын 13–15нд гурван өдрийн турш “Хархорин-Шим” ХХК-ны тариалангийн талбайн заагуудад хортон мэрэгчдийн эсрэг хорт өгөөш тавьж тэмцэх ажил хийгдсэн ба энэ ажилд нийт жимст цэцэрлэг хариуцсан бригадуудын хүн хүчийг мөн авч ажиллуулсан. Энэ ажилд 1-р бригадын 6 цэцэрлэгчийн 9 хүн/өдөр хүчээр 49,8 га талбайд, 2-р бригадын 4 цэцэрлэгчийн 4 хүн/өдөр хүчээр 24 га талбайд, 3-р бригадын 6 цэцэрлэгчийн 8,5 хүн/өдөр хүчээр 47,5 га талбайд, 4-р бригадын 5 цэцэрлэгчийн 7,5 хүн/өдөр хүчээр 41,5 га талбайд буюу агроүйлдвэрлэлийн 4 бригадын 21 цэцэрлэгчийн 29 хүн/өдөр хүчээр 162,8 га талбайд хорт өгөөш тавьж тэмцсэн.

5-р сард “Хархорин-Шим” ХХК-ийн тариан талбайн бордоог ачиж, буулгах зэрэг цагийн ажилд 3-р бригадын 6 цэцэрлэгчийн 9 хүн/өдөр хүчийг, 4-р бригадын 2 цэцэрлэгчийн 3,4 хүн/өдөр хүчийг буюу нийтдээ хоёр бригадын 8 цэцэрлэгчийн 12,4 хүн/өдөр хүчийг зарцуулсан.

5-р сард жимст цэцэрлэгийн талбайн ажилчидын гал тогоонд тогооч хийх зэрэг аж ахуйн ажилд 2-р бригадын 6 цэцэрлэгчийн 23,5 хүн/өдөр хүчийг, 3-р бригадын 1 цэцэрлэгчийн 1 хүн/өдөр хүчийг буюу нийтдээ 2 бригадын 24,5 хүн/өдөр хүчийг зарцуулсан.

2.5. 2019 оны хавар урд 20 хүлэмжнээс гаргасан тарьцын тариалалт, ургалтын үеийн арчилгааны талаар

2019 оны хавар 4-р сарын 16–с эхлэн хүлэмжинд буй тарьцуудын нахиа хөөж задарч эхэлсэн. 2018 оны зун компаний буюу урд хүлэмжийн аж ахуйн 6м X 40м хэмжээтэй 10 хүлэмж, 6м X 30м хэмжээтэй 10 хүлэмжинд тариалсан чацарганы тарьцуудыг бүгдийг нь ухаж гарган “Хархорин” ХК-ны 5Б дугаартай суулгац бойжуулгын талбайн зүүн талд нийтдээ 3,5 га талбайг хөгширч актлагдсан суулганаас нь чөлөөлж султгаад, ЮМЗ тракторын араас зүүсэн анжисаар хагалж хөрсийг нь боловсруулаад, агроүйлдвэрлэлийн дөрвөн бригадын цэцэрлэгчидийн хүчээр шинээр хайрцаг хийж тариалахад бэлтгээд мөн бригадуудын цэцэрлэгчидийн хүчээр 4-р сарын 28-с эхлэн 5-р сарын 24-н хүртэлх хугацаанд буюу хүн хүч маш их дутагдалтай байснаас шалтгаалан тарьц тариалалтын ажил ингэж бараг нэг сарын турш үргэлжилсэн.

Хавар 5-р сарын сүүлээс эхлэн хүлэмжний усалгаа, арчилгааны ажлыг агрономч Заяатын хариуцсан 3-р бригадын 1 цэцэрлэгчээр хийлгэж эхлэсэн.

2019 оны хавар урд хүлэмжнүүдээс тарьц ухаж гаргасан байдлыг дараах хүснэгтээр үзүүлэв.

Тариалсан таримлын төрөл, сорт	Ухаж		Тоо
	Эхэлсэн огноо	Дууссан огноо	
Эр тарьц	2019-04-28	2019-05-23	79886
Эм тарьц			517814
Үүнээс сорт, хүйс тодорхойгүй			216383
БҮГД			604603

1-р зэргийн үндэс сайтай, сайн тарьцуудыг нь ялган авч тариалсан. Ухаж гаргасан тарьцуудаас Хүлэмжний тарьцыг ухаж гарган, тоолж, ялгах ажилд энэ жил бойжуулгын 2-р бригадын хүн хүчийг л ашигласан.

4-р сарын 20 -ны өдөр сувгаар Орхон голоос ус урсгаж эхлэсэн ба гурван өдөр сувгийн усыг урсгаж цэвэршүүлээд, мөн хоёр хоногт усалгааны системээ усаар угааж цэвэрлээд, системээ дүүргээд, 4-р сарын 26-ны өдрөөс эхлэн талбайг услах боломжтой болгоод хүлэмжнээс гаргасан тарьцыг хайрцагт тариалж эхлэсэн.

Энэ жил бойжуулгын талбай болгохоор өмнө нь суулгац тариалаад борлогдоогүй байснаас шалтгаалж тариалсан суулгац нь хөгширч ургах чадвараа алдснаас болж актлагдсан 5Б талбайд зүүн талд нь 3,8 га талбай сонгоод түүндээ боловсруулалт хийж эхлэсэн. талбай бэлтгээд 4-р сарын 20–23-ны хооронд бойжуулгын 5Б талбайд 2013 онд тариалагдсан байсан, хөгширч актлагдсан чацарганы суулгацыг трактороор үндсийг нь хавж зөөлрүүлээд гараар талбайгаас түүж аван хуучин 6-р харуулын цэг байсан талбарруу зөөж асгах ажил хийгдсэн. Энэ ажилд бригадууд дараах байдлаар оролцсон. 1-р бригадын 9 цэцэрлэгчийн 23 хүн/өдөр хүчээр 4600 метр урт мөрний, 2-р бригадын 9 цэцэрлэгчийн 25 хүн/өдөр хүчээр 5000 метр урт мөрний, 3-р бригадын 6 цэцэрлэгчийн 16 хүн/өдөр хүчээр 3200 метр урт мөрний, 4-р бригадын 9 цэцэрлэгчийн 23,5 хүн/өдөр хүчээр 4700 метр урт мөрний буюу нийт дүнгээрээ дөрвөн бригадын 33 цэцэрлэгчийн 87,5 хүн/өдөр хүчээр

17500 метр урт мөрний суларсан хөгшин суулгацыг түүж аван тракторын чиргүүл дээр ачиж аваачиж асгасан.

4-р сарын 23-25-нд дээрх хөгширч актлагдсан суулгацаас нь чөлөөлсөн 5Б бойжуулгын талбайн зүүн үзүүрээс гурван удаагийн үйлдлээр 4 га талбайг ПУМА трактороор эргүүлэн хагалж, борнойдож тэгшлээд ЮМЗ-6 трактор болон 2-р бригадын 4 цэцэрлэгчийн хүчээр хайрцаг хийх шуудуу татуулаад, энэ жилийн бойжуулгын талбайн хайрцаг хийх ажил эхлэсэн.

4-р сарын 26-аас эхлэн гурван удаагийн үйлдлээр дээрх бойжуулгын талбайд 3м X 3м хэмжээтэй хайрцгууд хийж энэ жилийн хүлэмжний ногоон мөчрийн тарьц тариалах ажил хийгдсэн. Энэ ажилд нийт жимст цэцэрлэг хариуцсан бригадуудын бүх хүн хүчийг ашигласан ба үүнд:

4-р сард 1-р бригадын 7 цэцэрлэгчийн 17,5 хүн/өдөр хүчээр 176 хайрцаг, 2-р бригадын 11 цэцэрлэгчийн 18,4 хүн/өдөр хүчээр 178 хайрцаг, 3-р бригадын 7 цэцэрлэгчийн 15,5 хүн/өдөр хүчээр 130 хайрцаг, 4-р бригадын 9 цэцэрлэгчийн 26 хүн/өдөр хүчээр 265 хайрцгийг буюу дөрвөн бригадын 34 цэцэрлэгчийн 77,4 хүн/өдөр хүчээр 749 хайрцаг хийлгэж тариалалтанд бэлэн болгосон.

5-р сард 1-р бригадын 6 цэцэрлэгчийн 7,8 хүн/өдөр хүчээр 106 хайрцаг, 2-р бригадын 12 цэцэрлэгчийн 28,1 хүн/өдөр хүчээр 301 хайрцаг, 3-р бригадын 7 цэцэрлэгчийн 8,1 хүн/өдөр хүчээр 83 хайрцаг, 4-р бригадын 9 цэцэрлэгчийн 23,5 хүн/өдөр хүчээр 216 хайрцгийг буюу дөрвөн бригадын 34 цэцэрлэгчийн 67,5 хүн/өдөр хүчээр 706 хайрцгийг нэмж хийлгэн тариалалтанд бэлэн болгосон.

4-р сард 2-р бригадын 11 цэцэрлэгчийн 16 хүн/өдөр хүчээр хүлэмжний 282 нуруунаас 95429 ширхэг тарьцыг ухаж гарган ялгаж, тоолж, савлан пад тракторын чиргүүл дээр ачиж тариалалт хийж буй бригадуудад нийлүүлсэн.

5-р сард 2-р бригадын 12 цэцэрлэгчийн 95,5 хүн/өдөр хүчээр хүлэмжний 1495 нуруунаас 520631 ширхэг тарьцыг ухаж гарган ялгаж, тоолж, савлан пад тракторын чиргүүл дээр ачиж тариалалт хийж буй бригадуудад нийлүүлсэн.

Нийт дүнгээрээ 4 ба 5-р саруудад хүлэмжнүүдээс 616060 ширхэг тарьцыг ухаж гарган ялгаж, тоолж, савлан пад тракторын чиргүүл дээр ачиж тариалалт хийж буй бригадуудад нийлүүлсэн.

4-р сард 1-р бригадын 7 цэцэрлэгчийн 9,5 хүн/өдөр хүчээр 43 хайрцагт 16685 ширхэг тарьцыг, 2-р бригадын 10 цэцэрлэгчийн 4,9 хүн/өдөр хүчээр 20,2 хайрцагт 5216 ширхэг тарьцыг, 3-р бригадын 7 цэцэрлэгчийн 12,5 хүн/өдөр хүчээр 59 хайрцагт 21084 ширхэг тарьцыг, 4-р бригадын 9 цэцэрлэгчийн 8,6 хүн/өдөр хүчээр 52 хайрцагт 14974 ширхэг тарьцыг буюу нийтдээ дөрвөн бригадын 33 цэцэрлэгчийн 35,5 хүн/өдөр хүчээр 174,2 хайрцагт 57959 ширхэг тарьцыг тариалсан. Тарьц тариалсан хайрцаг услах ажилд 1-р бригадын 1 цэцэрлэгчийн 1,5 хүн/өдөр хүчээр 46 хайрцагийг, 2-р бригадын 1 цэцэрлэгчийн 0,1 хүн/өдөр хүчээр 20 хайрцагийг, 3-р бригадын 2 цэцэрлэгчийн 0,5 хүн/өдөр хүчээр 59 хайрцагийг, 4-р бригадын 2 цэцэрлэгчийн 0,8 хүн/өдөр хүчээр 42 хайрцагийг буюу нийтдээ дөрвөн бригадын 6 цэцэрлэгчийн 2,9 хүн/өдөр хүчээр 167 хайрцгийг усалсан.

5-р сард 1-р бригадын 8 цэцэрлэгчийн 39,7 хүн/өдөр хүчээр 271,3 хайрцагт 100373 ширхэг тарьцыг, 2-р бригадын 12 цэцэрлэгчийн 26,9 хүн/өдөр хүчээр 201 хайрцагт 47613 ширхэг тарьцыг, 3-р бригадын 7 цэцэрлэгчийн 28,6 хүн/өдөр хүчээр 158 хайрцагт 57223 ширхэг тарьцыг, 4-р бригадын 9 цэцэрлэгчийн 69,2 хүн/өдөр хүчээр 584,8 хайрцагт 169694 ширхэг тарьцыг буюу нийтдээ дөрвөн бригадын 36 цэцэрлэгчийн 164,4 хүн/өдөр хүчээр 1215,1 хайрцагт 374903 ширхэг тарьцыг тариалсан. Тарьц тариалсан хайрцаг услах ажилд 1-р бригадын 8 цэцэрлэгчийн 6,2 хүн/өдөр хүчээр 280,4 хайрцгийг, 2-р бригадын 3 цэцэрлэгчийн 1,7 хүн/өдөр хүчээр 183 хайрцгийг, 3-р бригадын 3 цэцэрлэгчийн 1,8 хүн/өдөр хүчээр 126 хайрцгийг, 4-р бригадын 9 цэцэрлэгчийн 9,8 хүн/өдөр хүчээр 575 хайрцгийг буюу нийтдээ дөрвөн бригадын 23 цэцэрлэгчийн 19,5 хүн/өдөр хүчээр 1164,4 хайрцгийг усалсан.

Мөн хавар суулгац ухаж гаргахад гарсан гологдол суулгацын тариалалт, усалгаа хамт орсон болно.

Бойжуулгын талбайн тариалалт дууссаны дараа бойжуулгын талбайг агрономч Мэнддолгорын 2-р бригадэд хариуцуулж өгөн арчлуулсан.

6-р сард бойжуулгын талбай хариуцсан 2-р бригадын 9 цэцэрлэгчийн 57 хүн/өдөр хүчээр 1997 хайрцагны гүн сийрүүлэлтийн ажилбар, 25 хүн/өдөр хүчээр 1988 хайрцгийг услуулах зэрэг ажилбаруудыг тус тус хийлгэсэн.

